



227

УЛААНБААТАР

хотын Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх Захиргааны ТОГТООЛ

1969 оны 7-р сарын 24-ны өдөр Дугаар 266

Улаанбаатар хот

ТЭЭВРИЙГ УДИРДАХ ГАЗРЫГ БАЙГУУЛАХ ТУХАЙ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1969 оны 141-р тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанаас **ТОГТООХ нь:**

1. Улаанбаатар хотын тээврийг удирдах газрыг 1969 оны 7-р сарын 1-нээс эхлэн байгуулсугай.

2. Хотын тээврийг удирдах газрын дүрмийг баталсугай.
/дүрмийг хавсаргав/.
З-ийн 1990 оны 140

3. Хотын тээврийг удирдах газар /н.БҮРНЭЭ/-д **ДААЛГАХ нь:**

а/ тээврийг удирдах газрын орон тоо, төсөв, зардал, харьяа газруудаасаа авах шимтгэлийн хэмжээг боловсруулан баталуулсугай

б/ хотын тээврийг удирдах газрын харьяалах авто аж ахуйнууд, гэдгээрийг удирдах журам зохион байгуулалтын талаар саналаа боловсруулан хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны хуралд 9-р сарын 10-ны дотор оруулсугай.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ 1-Р ОРЛОГЧ ДАРГА

Д.ШИРНИН

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦИАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫГ

С.БАЛЖИННЯМ



228
Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх
Захиргааны 1969 оны 7-р сарын 24-
ний өдрийн 266 р тогтоолоор
батлав.

ТЭЭВРИЙН УДИРДАХ ГАЗРЫН ДҮРЭМ.

Нэг. БЭЭНХИЙ ЗҮЙЛ...

1. Улаанбаатар хотын тээврийг удирдах газар нь нийслэл хотын хөдөлмөрчид албан байгууллагуудыг уналга хэсгээр үйлчилэх үйлчилгээг удирдан зохион байгуулах түүнийг улам хүрээмжтэй боловсронгуй болгож, нийслэл хотын тээврийн төвлөрсөн системийг бүрэлдүүлж цаашид хөгжүүлэх үндсэн зорилготой ажиллана.

2. Авто тээврийн хэрэгслэлийн ашиглалтыг дээшлүүлэн Улаанбаатар хотын доторхи Автобус, таксийн хөдөлгөөний зохицуулалтыг шуурхай болгох албан байгууллагын хотын доторхи тээврийн хэрэгцээг төвлөрсөн журмаар хангах үүрэг бүхий Улаанбаатар хотын Тээврийг Удирдах газар, УБ хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны харьяанд БНМАУ-ын Тээврийн яам, УБ Хотын АДХ-н гүйцэтгэх захиргааны хоёрдмол удирдлагатайгаар ажиллана.

3. Тус газар Улаанбаатар хотын доторхи хүн, ачаа тээвэрлэх зорилготой авто аж ахуйнуудыг харьяалан удирдаж тэдгээр газруудаас зохих хувиар шимтгэл авч санхүүжих замаар аж ахуйн тооцоон дээр ажиллана.

4. Улаанбаатар хотын тээврийг удирдах газрыг Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанаас томилогдсон дарга тологдолох бөгөөд тэр нь газрын бүх ажлыг зохих цугамаар нь БНМАУ-ын Тээврийн Яам, Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны өмнө харицаж дээд байгууллагын шийдвэр Улсын хууль тогтоомжийг биелүүлэх үндсэн дээр эрх хэмжээнйхээ дотор тушаал заавар гаргана.

5. Улаанбаатар хотын тээврийн удирдах газар тогтоосон журмаар хийгдсэн тамга тэмдэг бичгийн нүүр хэрэглэнэ.

Хоёр. УЛААНБААТАР ХОТЫН ТЭЭВРИЙГ УДИРДАХ
ГАЗРЫН ЭРХ ҮҮРЭГТ

6. Хотын ерөнхий төлөвлөгөө, хотын байгуулалта, иргэдийн орон барилгын байршилтын тухайн үеийн үндсэн дээр хотын хүн амын тээврийн үйлчилгээний зохистой маршрут түүний зогсоолын цэгийг зөвөөр сонгосон тогтоох асуудлыг боловсруулан батлуулж, түүнийг хэрэгжүүлэн биелүүлж байна.

7. Хотын автобус, такси тээврийн шугамын хөдөлгөөний графикийг батлаж түүний биелэлтэнд хяналт тавьж диспетчрийн төвлөрсөн удирдлага, зохицуулгаар хангаж байна.

8. Хотын ачаа тээвэрлүүлэгч байгууллагуудын жил удиралын тээвэрлүүлэх ачааны захиалгыг авч аж ахуйн ерөнхий гэрээ байгуулж түүний үндсэн дээр байгууламжууд хороондоо аж ахуйн гэрээ байгуулж ажиллах бөгөөд энэ гэрээний биелэлтэнд байнгын хяналт тавьж ажиллана.

9. Авто тээвэрээр ачаа тээвэрлэх дүрэм, аймаг, хотын доторхи ачаа тээврийн диспетчрийн удирдлагын зааврын дагуу хотын доторхи тээврийн үүрэг гүйцэтгэдэг базуудын ажлыг диспетчрийн нэгдсэн удирдлага, зохицуулгаар хангаж, эдөр тутмын ажилд нь байнгын хяналт тавьж байна.

10. Хотын хүн тээврийн автобус, такси, болон ачаа тээвэр үйлчилгээний авто базуудын засвар үйлчилгээний ажлыг зохион байгуулах, шаардагдах шатахуун салбарт материалын хэрэгцээг гаргах захиалга хийх, хувиарлах ажлыг зохион байгуулж байна.

II. Хотын тээврийн авто базуудад тэргүүний давшилттай хөдөлмөр зохион байгуулалт норм цалин хөлсний системийн нэвтрүүлэх ба энэ талаар холбогдох судалгаа шинжилгээг хийж арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлж байх.

12. Хотын тээврийн базуудын төлөвлөрөө, статистик, санхүү тайлан бүртгэлийн ажлыг шалгаж удирдан зохион байгуулаж, техник тээвэр санхүүгийн төлөвлөгөөг захиолгон батлах, төлөвлөгөөт ажлын биелэлтэнд хяналт тавьж ажиллана

13. Хотын автобус такси ба бусад ачаа үйлчилгээний тээврийн базуудын хүч чадлыг тээврийн ажлын хэмжээний өсөлт хөдөлмөрчдийн хэрэгцээ шаардлагын дагуу зөвөөр тогтоох өргөтгөх, материалтехникийн базыг байнга бэхжүүлэх шинээр байгуулах, авто тээврийн үйлчилгээний цэг салбаруудыг нэмэх ба татан буулгах асуудлуудыг боловсруулж дээд байгууллагад оруулана

14. Харьга байгууллагуудын мэрэгшил дадлагатай боловсон хүчнээр байнга хангаж байх ажилчин ажилтан нарын мэрэгшил боловсрол, дадлагыг тусгай төлөвлөгөөтэйгээр байнга дээшлүүлж боловсонхүчнийг хувиарлах, томилох ажлыг хариуцна.

15. Тээврийг удирдах газар нь байшин байгууллагатай тусгай харилцахданстай байна.

-----"II"-----

нийл.....
Б/-Ц-Базаррагчаа.